



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/861

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.2 дахь заалтын “Хууль, журам-миний амьдралд” аян зохион байгуулах гэсний дагуу 2020 онд зохион байгуулах аяны сурталчилгааны баннер хийлгэх зардалд 850.000, Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдэд зориулсан Баруун бүсийн сургалтын арга хэмжээнд зориулж 500.000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 1.350.000 төгрөг /нэг сая гурван зуун тавин мянган/-ийг “Тайван-амгалан-Ховдчууд” хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөршөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

